

## 2007 ОНД МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН ЖАГСААЛТ

- 02.16 Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд Фридрих Эбертийн сангийн Ази, Номхон далайн газрын дарга, хатагтай Биате Бартольдус, тус сангийн Монголыг хариуцсан захирал Роланд Файхт нарыг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр ноён Роланд Файхтыг МАХН-ын шагнал болох “Хүндэт тэмдэг”-ээр шагнасныг Ерөнхий сайд, МАХН-ын дарга М.Энхболд гардуулав.
- 03.15 Монгол, Оросын парламентийн бүлгүүдийн уулзалт Улаан-Үд хотод болов. Уулзалтад УИХ-ын гишүүн, Монгол, Оросын парламентийн бүлгийн дарга Д.Идэвхитэн болон Ч.Авдай, Р.Нямсүрэн, Д.Арвин, Б.Батбаяр нарын гишүүд, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын Гаалийн ерөнхий газар, Улсын Мэргэжлийн Хяналтын алба, Хөдөө аж ахуй, Үйлдвэр, худалдааны яамны төлөөлөгчид оролцжээ. Оросын талаас төрийн Думын Орос-Монголын парламентийн бүлгийн ахлагч В.Войтенко тэргүүтэй Думын гишүүд, Оросын Холбооны Буриад улсын Ерөнхийлөгч В.Потапов, Оросын Холбооны Улсын хил гаалийн удирдлагын албаны хүмүүс оролцсон байна. Талууд энэ удаагийн уулзалтаар хоёр орны худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн солилцоог өргөжүүлэх, хилээр иргэдийг хүнд сурталгүй шуурхай нэвтрүүлэх, иргэд харилцан визгүй зорчих асуудлаар санал солилцов.
- УИХ-ын гишүүн, Монгол Улсын шадар сайд М.Энхсайхан Шведийн Вант Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд, ноён М.Линдстромыг өөрийнх нь хүсэлтээр хүлээн авч уулзав. Шведийн засгийн газраас үзүүлж буй хөгжлийн тусламж нь Монгол Улсад ардчилалыг бэхжүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсыг хангах, ядуурлыг бууруулах, чөлөөт болон олон нийтийн хэвлэлийн тогтолцоог бүрэлдэн бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулж буйг Шадар сайд М.Энхсайхан мөн дурдав. Ноён элчин сайд Линдстром монголчуудын өвөрмөц соёл, зан заншил амьдралын хэвшлийг ихэд сонирхож явдгаа хуучлаад хоёр орны хамтын ажиллагааг цаашид улам эрчимжүүлэхээ онцлов. Элэгсэг дотно болсон уулзалтад Шведийн Элчин сайдын яамны хоёрдугаар нарийн бичгийн дарга Николас Вийкс, Монгол дахь өргөмжлөлт консул Л.Болдхуяг болон ГХЯ-ны албаны хүмүүс байлцав.

- 04.03 УИХ-ын дарга Ц.Нямдорж Европарламентийн гишүүн Чех улсын анхны сансрын нисгэгч Владимир Ребекиг хүлээн авч уулзав. Уулзалтад УИХ-ын гишүүн Ж.Гуррагчаа оролцсон байна. Тэрээр Монгол Улс Европийн Холбооны улсууд, европарламенттай харилцаагаа улам идэвхижүүлэх сонирхолтой байдаг гээд ноён Владимир Ребекиг дэмжин ажиллахыг хүсэв.
- 04.04 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт Япон улсаас манай улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Я.Ичихаши бараалхав.  
Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт Бүгд Найрамдах Македони Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Жиладин итгэмжлэх жуух бичгээ барив.  
УИХ-ын дэд дарга тэргүүтэй төлөөлөгчид БНКУ-д айлчлаад ирэв. Айлчлалын бүрэлдэхүүнд Куба-Монголын парламентийн бүлгийн дарга УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Э.Бат-Үүл, Ц.Баярсайхан, Б.Бадамжунай нар оролцов. Тэд БНКУ-ын Ардын Засгийн Үндэсний ассамблейн дарга Рикардо Аларконтой уулзаж хоё улсын харилцааны талаар ярилцсан бөгөөд Монгол Улсын төлөөлөгчид Ардын засгийн үндэсний ассамблейн дэд дарга Хайме Кромбелтэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.
- 04.10 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярт Монгол Улсад айлчилж буй АНУ-ын энх тайвны корпусын захирал Роналд А.Четтер тэргүүтэй төлөөлөгчид бараалхав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр АНУ-ын Энх тайвны корпус сайн дурынхнаа Монгол Улсад илгээн, хөдөөд хүүхдүүдэд англи хэл заахын зэрэгцээ эрүүл мэндийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулж байгаад талархал илэрхийлсэн байна. Ноён Р.А.Четтер, Энх тайвны корпусынхан нийгмийн үндэс суурь болсон анхан шатны түвшинд ажиллаж соёлын солилцоо ард түмнүүдийн харилцан ойлголцолд хувь нэмэр оруулдаг. Энх тайвны корпус Монгол Улстай урт хугацаагаар хамтран ажиллах болно гээд Монгол Улсын төрийн тэргүүнийг АНУ-д айлчлахдаа Энх тайвны корпус зочлохыг урив.
- 04.17 Ерөнхийлөгч Н.Энхбаяр Бахрейны Вант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Карим Эбрахим Ал-Шакарыг эх орондоо бүрмөсөн буцаж байгаатай нь холбогдуулан хүлээн авч уулзав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Бахрейны Вант улсын Цог жавхлант Эзэн хаан Х.И.Ал-Калифад мэндчилгээ дэвшүүлж байгааг уламжлахыг хүсээд

Монгол Улс Бахрайн болон булангийн орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг ялангуяа эдийн засгийн салбарт хөгжүүлэх сонирхолтойг онцлон тэмдэглэв. Бахрейны Вант Улсын элчин сайд К.Э.Ал-Шакар хөдөө аж ахуйн салбарт болон техникийн хамтын ажиллагаа хөгжүүлэх санаачлага Монгол Улс гаргасныг Бахрейн улс талархан хүлээж авсан гээд хоёр орны хооронд эдийн засаг худалдааны харилцаа хөгжүүлэх боломж байгааг тэмдэглээд мөн тус улс Ази, Номхон далайн орнуудаас хүнсний зориулалтаар хонь импортолдгийг болон Бахрейнаас Монголд хөрөнгө оруулалт хийх бололцоо байгааг дурдав. УИХ-ын гишүүн, эрүүл мэндийн сайд Д.Туяа Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн Эрхт Элчин сайд Жив Неквасилыг хүлээн авч уулзав. Чех улсын засгийн газраас “Улсын клиникийн төв эмнэлгийн барилга тоног төхөөрөмжийг шинэчлэх” төслийг 1999-2003 онд 30.0 сая кроны тусламж үзүүлсэн юм. 2005-2010 онд хэрэгжих төслийн хоёр дахь шатанд 48.0 сая чех кроны будалтгүй тусламжийг оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, эмч нарын мэргэжлийг дээшлүүлэх, цахилгаан шатыг засварлахад зарцуулж байгаа аж.

04.19

Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр Их Британи Умард Ирландийн нэгдсэн вант улсын Ерөнхий сайд Тони Блейртэй уулзаж хоёр орны харилцаа хамтын ажиллагааны тодорхой асуудлаар санал солилцов. Ялангуяа Европийн Холбооны орнуудад Монголын бараа бүтээгдэхүүнийг импортын татваргүй оруулах асуудалд дэмжлэг үзүүлсэн нь хоёр орны харилцааны чухал үйл явдал юм. Цаашид эдийн засаг худалдаа хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр хамтран ажиллах, Монголын зах зээлд Их Британий пүүс компаниудыг олноор татан оруулах сонирхолтой байгаагаа онцлон хэлэв. Ерөнхий сайд Тони Блейр Монгол Улсын ерөнхийлөгчийн эдийн засаг, худалдааны харилцааг илүү өргөжүүлэх талаар тавьсан саналуудыг чухал хэмээн хүлээн авч дэмжиж ажиллахаа илэрхийлэв. Тэрээр мөн Монгол Улс Ирак, Афганистан, Сьерра Льеон зэрэг орнуудад энхийг сахиулах үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрээ оруулж, хамтран ажиллаж байгааг өндрөөр үнэлэв.

Батлан Хамгаалахын сайд С.Сономпил ХБНГУ-д 16-27-нд тус улсад болж буй Ж.Маршалын нэрэмжит Европийн аюулгүй

байдлын судалгааны төвийн дээд түвшний удирах ажилтны семинарт Монгол Улсаа төлөөлөн оролцов. Семинарт оролцогчид НАТО-гийн болон Европийн холбооны хүрээ өргөжин тэлж байгаатай холбоотой гарах асуудал болон гишүүнчлэлийн талаар хэлэлцэхээр төлөвлөжээ. Мөн энэ бүхэн нь Евро-Атлантын бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад хэрхэн нөлөөлсөн, тус нутагт ардчилал, хууль ёсыг дэлгэрүүлэхэд гүйцэтгэж буй үүргийн талаар санал бодлоо хуваалцав.

- 04.20 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр Лондон хотноо Европийн сэргээн босголт, хөгжлийн банкны удирдлагуудтай уулзав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол орны цаашдын хөгжилд ашигт малтмал, уул уурхайн салбар голлох үүрэгтэйг онцлоод энэ чиглэлд хамтран ажиллах эрмэлзэлтэй байна гэв.
- 05.15 Дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойг тохиолдуулан АНУ-д Монголын өдөрлөгийг зохиов. АНУ-ын хөдөлмөрийн яаманд тус өдөр болсон бөгөөд Хөдөлмөрийн сайд Илейн Чао, элчин сайд Р.Болд нар өдөрлөгийг нээж үг хэлсэн байна.
- 05.22 Монгол Улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагч Н.Энхбаярт БНХАУ-ын ардын чөлөөлөх армийн жанжин Штабын дарга, цэргийн төв зөвлөлийн гишүүн, хурандаа генерал Лян Гуэнлэ тэргүүтэй төлөөлөгчид бараалхав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр хоёр орны хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаагийн дотор батлан хамгаалахын салбарт буцалтгүй тусламж олгосон нь батлан хамгаалахын бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулсан. Мөн сургалтын чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлж байгаад баяртай байгаа ба Монгол Улс цомхон чадварлаг армитай болохыг зорьж байгааг онцлон тэмдэглээд дэлхий нийт хөгжиж байгаа өнөө үед хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь чухал гэв. Хурандаа генерал Лян Гуэнлэ БНХАУ-ын Ерөнхийлөгч Ху Жинтаогийн мэндчилгээг Монгол Улсын төрийн тэргүүнд уламжлаад, хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх талаар санал нэг байна. 2007 онд Монгол Улсын Батлан хамгаалах яаманд БНХАУ-аас 14 сая юанийн буцалтгүй тусламж үзүүлэхээс 8 сая юанийн бараа бүтээгдэхүүн, 6 сая юань нь офицерүүдийг БНХАУ-д сургахад зориулагдахаар, мөн хилийн цэрэгт 3 сая юанийн тусламж үзүүлнэ гэв.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 63-р чуулганы сайд нарын төвшний хуралдаан Алма-Ата хотноо эхлэв. Тус чуулганд Монгол Улсын төлөөлөгчдийг тэргүүлэн Шадар сайд М.Энхсайхан “АНД-ын бүс нутагт Мянганы хөгжлийн зорилтууд хэрэгжүүлэх нь” сэдэвт илтгэл тавив. Шадар сайд М.Энхсайхныг НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга Др.Ким Хаксу хүлээн авч уулзав.

Монгол Улс ОХУ-тай соёлоор харилцах нийгэмлэг байгуулагдсаны 60 жилийн ой тохиов. Тус нийгэмлэг манай боловсрол соёл шинжлэх ухааны салбарын сэхээтнүүд санаачлан хоёр орны соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх, өөрийн хэл, зан заншлаа гадаадын улс оронд сүлалчилахаар байгуулжээ. ОХУ-ын шинжлэх ухаан соёлын төвд болсон ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, хоёр орны найрамдын нийгэмлэгийн тэргүүнүүд, ОХУ-аас манай улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин Сайд О.Говорин болон урлаг соёлын ахмад зүтгэлтнүүд оролцов.

05.24 АНУ дахь Монгол Улсын ЭСЯ, Америкт амьдарч буй Монгол иргэдийн байгуулсан “Соёмбо” төвтэй хамтран Монгол судлалын анхдугаар бага хурал хийв. Эх хэл, соёл заншил урлагаа суртчилах, АНУ-д оршин суугаа монгол иргэдийг ойртуулан нэгтгэх, монгол судлал болон, урлаг соёл, эрдэм судлалын чиглэлээр ажилладаг байгууллага, хувь хүмүүсийн хөхиүлэн дэмжих, ажил үйлсийг нь таниулахад бага хурлын гол зорилго чиглэсэн байна.

ОХУ-ын Саха улсын урлаг соёлын зүтгэлтнүүд манай ерөнхийлөгчид бараалхав. Бүрэлдэхүүнд нь тус улсын соёлын сайд А.С.Борисов, Ерөнхийлөгчийн тамгын газрын үндэстэн хороодын асуудал эрхэлсэн албаны дарга А.Мигалкин болон ОХУ-ын ардын уран зохиолч Н.А.Лугинов нарын хүмүүс байв. Уулзалтын үеэр хоёр улсын театр, кино, утга зохиол, соёлын салбарын хамтын ажиллагааны талаар халуун дотно яриа өрнүүлжээ. Ерөнхийлөгч Н.Энхбаяр түүх, соёл уламжлалтай нь нэн ойр тэдэнтэй уулзаж байгаадаа баятай байгаагаа илэрхийлэв.

05.28 Ерөнхийлөгч Н.Энхбаярт БНСУ-ын Ерөнхий прокурор Чон Сан Мюн бараалхав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт гээд бүхий л салбарт өрнүүн хөгжиж байгаагийн дотор хууль хяналт, прокурорын байгууллагын хамтын ажиллагаа тодорхой байр суурь эзэлж байгааг тэмдэглэв. БНСУ-ын Ерөнхий прокурор Чон Сан Мюн 2000 онд хоёр улсын

- прокурорын байгууллагуудын хооронд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан, уг гэрээний дагуу хамтын ажиллагаа өрнөж буйг танилцууллаа. Хоёр орны прокурорын байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх ерөнхийлөгчийн хэлснийг анхаарч ажиллахаа илэрхийлэв.
- 06.05 Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНСУ-д төрийн айлчлал хийв. Айлчлалын үеэр БНСУ-ын ерөнхийлөгч Но Мун Хентэй уулзахдаа хоёр орны ХАА-н салбарын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар дэлгэрэнгүй ярилцсаны дотор Монголын Дорнод бүс нутгийг хөгжүүлэх, энэ ажилд зүүн хойд Ази эхний ээлжинд БНАСАУ-ыг оролцуулах саналтай байна гэдэг дээр санал нэгдэв.
- 06.25 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт Швейцарийн хөгжлийн агентлагийн дэд захирал Ремо Гаучи бараалхав. Ноён Р.Гаучи цөлжилт Монголд эрчимжиж байгаа, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, малчдад туслах, хөдөөд жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж бизнес эрхлэх, зөвшөөрөл авахад нэг цэгийн үйлчилгээгээр лиценз олгодог болох асуудлуудад Швейцарийн хөгжлийн агентлаг ахнаарлаа хандуулан ажиллаж байгаа талаар танилцуулав.
- 06.26 БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Гао Шу Маог Монгол Улсын барилгын, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт хүлээн авч уулзав. Энэ үеэр элчин сайд Гао Шу Маогийн Монгол Улсын барилгын салбарт оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, “Барилгын тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнасан юм. Тэрээр дараагийн Элчин сайдад Хятад-Монголын барилгын салбарын хамтын ажиллагааны талаар онцлон танилцуулах болно, мөн Монголд оруулж байгаа Хятадын хөрөнгө оруулалт бусад орныхоос харьцангуй өндөр байдаг талаар дурдав.
- 07.03 БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ян Женийг Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд хүлээн авч уулзав. БНХАУ манай орны хөрөнгө оруулалт, гадаад худалдааны хамгийн том түнш орон бөгөөд бусад салбарын харилцаа ч хөгжиж байна. Тэд манай оронтой эрчим хүч, биеийн тамир спорт, орон сууцны хороолол барих ажилд хамтран ажиллахыг илүү эрхэмлэж байгаа бөгөөд эдгээрт хамтрах байгууллага, компаниудад олон улсын жишигт нийцсэн хэм, хэмжээний шаардлагыг тавих болно гэв. Тэрээр цааш нь БНХАУ МУ-ын тавьсан аливаа асуудалд сайн хөршийн сэтгэлээр ханддаг. Спортын ордон, Төв лаборатори барих асуудлыг бид анхаарч байна. Цаашид

соёл спортыг дэмжих, монголоос сургах оюутны тоог нэмэгдүүлэх талаар анхааран, ажиллах болно гэв.

АНУ-ын конгрессын Төлөөлөгчдийн Танхимын Ардчиллыг дэмжих комиссын төлөөлөгчид Төрийн ордонд УИХ-ын эрхэм гишүүдтэй уулзав. АНУ-ын конгрессын эдгээр төлөөлөгч УИХ-ын гишүүдэд парламентийн ард түмэндээ тайлагнах, чадавхи, хариуцлагыг дээшлүүлэх, ил тод нээлттэй байх, хууль тогтоох үйл ажиллагаагаа хараат бус явуулах, гүйцэтгэл зсаглалд хяналт тавих зэрэг асуудлаар арга зүйн зөвөлгөө өгч, туршлагаасаа хуваалцав.

07.20 БНАСАУ-ын Ардын дээд хурлын Тэргүүлэгчдийн дарга Ким Ён Нам Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар 2007 оны 7 дугаар сарын 20-23 хооронд гурав хоногийн хугацаатай Монгол Улсад албан ёсны найрсаг айлчлал хийв. Уг айлчлал нь БНАСАУ-ын талаас 19 жилийн дараа манай улсад хийж байгаа өндөр хэмжээний айлчлал байв.

07.24 Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярт АНУ-ын төрийн департаментын Ойрхи Дорнодын асуудал хариуцсан туслах нарийн бичгийн даргын орлогч Элчин Сайд Лоренс Батлер, Батлан хамгаалахын Төрийн нарийн бичгийн даргын тамгын газрын Ирак, Афганистан дахь эвслийн ажиллагаа хариуцсан захирал Петер Маквети, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд Марк Минтон тэргүүтэй төлөөлөгчид бараалхав. Элчин сайд Лоренс Батлер, П.Маквети нар Иракийн сэргээн босголтын төлөө АНУ-ын эвслийн хамтын ажиллагаанд Монгол Улс чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэж, АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш, Төрийн нарийн бичгийн дарга Р.Гейтс нар Монгол Улс Иракт цэргийн бие бүрэлдэхүүн, наймдугаар ээлж илгээсэнд талархал илэрхийлснийг Монгол Улсын төрийн тэргүүнд уламжлав.

07.31 УИХ-ын дарга Д.Лүндээжанцан манай улсад айлчилж буй Кувейт улсын эрхэм дээд Эмир Шейх Сабах Аль-Ахмад Аль-Жабэр, Аль-Сабахт нар бараалхав. Уулзалтын үеэр УИХ-ын дарга Д.Лүндээжанцан энэхүү айлчлал нь хоёр орны харилцааг шинэ шатанд гаргана хэмээгээд Монгол Улс зах зээлд шилжсэн үеийн хүнд хэцүү цагаас эхлэн Кувейтийн сан тусалж дэмжиж ирсэнд талархав. Мөн Кувейтийн тал энэ удаад манай орны дэд бүтцийг хөгжүүлэхэд хөнгөлөлттэй зээл олгох мөн парламентийн харилцаа идэвхитэй хөгжиж парламентийн ордон барихад бодит дэмжлэг үзүүлснийг УИХ-

- ын дарга онцлон талархал илэрхийлэв. Уулзалтын үеэр хоёр тал парламентийн ордоны талаар тогтож санал солилцов.
- 08.14 МУ-ын ерөнхийлөгч Н.Энхбаяр Казакстан улсад төрийн айлчлал хийв. Энэ айлчлал нь тус улсын ерөнхийлөгч Н.Назарбаев манай улсад 1999 онд айлчилсаны хариу бөгөөд хоёр орны түүхэнд шинэ хуудас нээх ач холбогдолтой байв. Уулзалтын үеэр хоёр орны ерөнхийлөгчийн яриа хэлэлцээрийн үр дүнг тусгасан хамтарсан мэдэгдэл, аялал жуулчлалын, архивын салбарт хамтарч ажиллах тухай болон хоёр орны Дотоод Хэргийн Яамдын хамтын ажлын хэлэлцээрүүд байв.
- 08.28 БНБУ-ын Ерөнхийлөгч Георги Пырванов гэргийн хамт, ерөнхийлөгчийн танхимын дарга Н.Колев, гадаад хэргийн орлогч сайд Ф.Чаушев болон бусад төлөөлөгчдийн хамт МУ-ын ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхав.
- 09.11 УИХ-ын дарга Д.Лүндээжанцан тэргүүтэй төлөөлөгчид БНУУ-ын ерөнхийлөгч, эрхэмсэг ноён Шойом Ласлод бараалхав. Уулзалтын үеэр хоёр орны хооронд бүх талын харилцааг хөгжүүлэхийг дэмжиж, тэр дундаа соёл боловсрол шинжлэх ухааны салбарыг онцлов.
- 10.01 Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Сайд Марк Минтон, ЭСЯ-ны консулын хэлтсийн дарга Лыза Корнер нарыг хүлээн авч уулзав. Иргэд харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх, улмаар визгүй зорчих журамд шилжих боломжийн талаар санал тавьж ярилцав.
- 10.09 Монгол, Чехийн Гадаад хэргийн яамдын зөвлөлдөх уулзалт болов. Уулзалтад Чехийн талаас Гадаад хэргийн дэд сайд Х.Бамбасова, ГХЯ-ны Азийн газрын захирал Янфури, дэд сайдын туслах Мартин Кубичек, Монголын талаас Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон, Монгол Улсаас БНЧех улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд О.Энхтөр, ГХЯ-ны Европийн газрын захирал Ш.Одонбаатар нар оролцов. Чехийн тал манай улсыг өөрийн Ази тив дэх чухал харилцаатай орон гэж үнэлэн, хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгааг тэмдэглэж хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам үр дүнтэй болгохын төлөө хамтран ажиллахаа илэрхийлэв.
- 10.10 Швейцарийн Холбооны улсын Женев хотод 8-10 өдрүүдэд зохиогдсон Олон Улсын парламентийн холбооны 117-р ассамблейд Монгол улсын их хурлын дэд дарга Д.Идэвхтэн тэргүүтэй төлөөлөгчид оролцов.



- 10.22 АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярыг Цагаан ордондоо хүлээн авч уулзав. Хоёр орны тэргүүн нар терроризмын эсрэг дайн, Иракт гарч буй ахиц дэвшил болон худалдаа, эдийн засгийн хөгжил, иж бүрэн түншлэлийн харилцааг улам баяжуулж, хүрээг нь тэлэх, цацраг идэвхт бодис хилээр нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэхэд хамтран ажиллах тухай засгийн газар хоорондын санамж бичиг зэрэг хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зурав.
- 12.03 Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын Персийн булангийн орнуудад хийсэн айлчлал Арабын Нэгдсэн Эмират улсаас эхлэв. Айлчлалын үеэр хоёр орны хамтын ажиллагааны талаар санал солилцон хэлэлцээр хийж, зарим баримт бичигт гарын үсэг зурав. Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр махчин шувууг хамгаалах талаар Абу Дабигийн сантай хамтран ажиллахаар болж Байгаль орчны дэд сайд Д.Энхмандах санамж бичигт гарын үсэг зурав.
- Ерөнхийлөгч дараагийн айлчлалаа Кувейт улсад хийв. Айлчлалын үеэр Кувейтийн тал Монголд парламентийн ордон барихад зориулж 12 сая ам.долларын буцалтгүй тусламж олгохоо мэдэгдэж, төслийн санхүүжилт удахгүй хийгдэнэ гэдгийг тэмдэглэв.
- Ерөнхийлөгчийн дараагийн айлчилсан улс нь Катар байв. Тус улсад манай ерөнхийлөгч нэг хоног саатахдаа албан ёсны хэлэлцээрийн үеэр ярьсан гол зүйл бол нефть бүтээгдэхүүн импортлох тухай санал байв. Катарын тал ч уг саналыг нааштайгаар хүлээж авав.

*Мэдээ бэлтгэсэн Б.Мандхай (ОУСХ-ийн  
эрдэм шинжилгээний ажилтан)*